



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 198,000,000.00 (нэг зуун ерэн найман сая) төгрөгийн балансын үнэ, 30,250,000.00 (гучин сая хоёр зуун тавин мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Зам, тээврийн хөгжлийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000233

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 83
дугаар тогтоолын хавсралт

Иргэний нисэхийн ерөнхий газраас балансаас Зам, тээврийн хөгжлийн яамны балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

Д/д	Эд хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ Ашиглалтанд орсон огноо	Хэм жих нэгж	Тоо ширхэг	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	Ниссан патрол маркийн, УБЗ 01-51 улсын дугаартай- JN1TANY62Z0100012, Хөдөлгүүрийн дугаар- 242541	2018/01/19	ш	1	198,000,000.00	30,250,000.00	167,750,000.00
				1	198,000,000.00	30,250,000.00	167,750,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			1 (нэг)	198,000,000.00 (нэг зуун ерэн найман сая)	30,250,000.00 (гучин сая хоёр зуун тавин сая)	167,750,000.00 (нэг зуун жаран долоон сая долоон зуун тавин мянга)